| 3 | III.Төсөв, санхүүгийн чиглэлээр | 73% | А/Байр хариуцсан менежер байгууллагын хөрөнгө матеиал хяналт тавьж ажиллах,<br>Б/ Ариун цэврийн өрөөний үйлчлэгчдэд байнгын маск зүүж ажиллуулах |
| 4 | IV.ХАБЭА, Стандарт норм норватив, хэрэгжүүлж буй байдал | 78% | 2021 оны А/10 дугаар тушаалаар баталсан "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий шаардлага"<br>2019 оны А/18 дугаар тушаалаар баталсан "Ажлын байрны цэвэрлэгээ үйлчилгээ, үйлчилгээний ерөнхий шаардлага" /НҮГ-01:2019/ хэрэгжихгүй байна. Сурталчлан таниулах ажил хийгдэх, өдөр тутмын болон давтан зааварчилгаа өгөх шаардлагатай, ариутгал халдваргүйжүүлэлтийн бүртгэл хөтөлдөггүй, нэг бүрийн хамгаалах хэрэгслийг хэрэглэж хэвшсэн байна. |
| 5 | V.Төлөвлөгөө тайлан, батлагдсан хуваарийг хэрэгжүүлж ажиллах чиглэлээр | 78% | Гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний биелэлт тайлагнасан байдалтай танилцахад албан тушаалын тодорхойлолтын зорилтын хүрээнд хийгдэх арга хэмжээг бүрэн тусгаагүй, төлөвлөлт хэт ерөнхий, тодорхой бус,<br>Баримт бичиг боловсруулахдаа /Төлөвлөгөө, тайлан, илтгэх хуудас, мэдээлэл, судалгаа/ баримт бичгийн бүрдэл хангаагүй, |
| 6 | VI.Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах чиглэлээр | - | - |
| **Ерөнхий үнэлгээ** | | 76% | |

## 10.Сэлбэ дэд төв

Ажлын хэсэг 2023.11.23-ны өдрийн 10:00-12:00 цагийн хооронд ажиллалаа. Менежерээр Ц.Өнөрбилэг, үйлчилгээний 10 ажилтны хамт нэгдсэн төвийн 4, хувийн хэвшил 23 байгууллагын 78 гаруй албан хаагчдын ая тухыг хангахаар ажиллаж байна.

Ажиллавал зохих: 10 ажилтан
Ажиллаж байгаа: 10 ажилтан



Зураг23. Сэлбэ төвийн ажилчидтай уулзав.



Зураг24. Сэлбэ төвийн мэдээллийн самбар



Зураг25. Сэлбэ төвийн цэвэрлэгээний тэмдэглэл



Зураг26. Төвийн ажилчдын хувцаслалт

Сэлбэ төвийн үнэлгээний нэгтгэл

| № | Шалгах чиглэл, шалгуур үзүүлэлт | Хэсгийн дундаж үнэлгээний хувь | Үнэлгээний үндэслэл, тайлбар |
|---|---|---|---|
| 1 | I.Хууль, тогтоомж дүрэм журмын чиглэлээр | 71% | Хүчин төгөлдөр бус захирамжлалын баримт бичгийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байгаа нь дутагдалтай. Мөрдөгдөж байгаа дүрэм журмуудыг хэвлэж, хавтасласан боловч судлаагүй, ажилтан албан хаагчдад тайлбарлан таниулж гарын үсгээр баталгаажуулаагүй. |
| 2 | II.Хүний нөөцийн чиглэлээр | 69% | -Удирдамжийн дагуу бичиг баримтын бүрдэлийг хангаагүй<br>-Ажилчдын хувийн хэрэг үүсгэсэн нь Төрийн албаны тухай хууль 15.1 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоол “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам” Төрийн албан хаагч бүрд зөвхөн нэг хувийн хэрэг хөтөлнө. Хувийн хэргийг тухайн албан хаагчийн ажиллаж буй байгууллагын захиргаанд хадгална гэсэн заалтыг зөрчсөн.<br>-Ажлаас чөлөөлөгдсөн ажилтантай ажил хүлээлцэх акт үйлдэж баталгаажуулаагүй,<br>-Хамт олны уур амьсгал, тэдгээрийг идэхжүүлэх зорилгоор дотооддоо шинээр ажил зохион байгуулаагүй,<br>-Бичиг баримтыг тухай бүр баталгаажуулан хавтас үүсгэдэггүй, бичиг баримтын стандарт хангалтгүй эмх цэгцгүй, он оны бичиг баримт холилдсон,<br>-Их цэвэрлэгээ ариутгалын хуваарийг газрын даргаар батлуулсан ч 100% дагаж мөрддөггүй<br>-Өдөр тутмын цэвэрлэгээ хийсэн тухай тэмдэглэл, цэвэрлэгээ үйлчилгээг шалгах хяналтын хуудсыг тухай бүрт бүрэн гүйцэд хянаагүй, 10 сараас эхлэн тэмдэглэл хөтөлсөн,<br>-Захиргаанаас гарсан шийдвэр холбогдох мэдээ мэдээллийг ажилчдад тогтмол мэдээлсэн тухай хурлын тэмдэглэл хөтөлж баталгаажуулдаггүй зөрчлүүд илэрсэн. |
| 3 | III.Төсөв, санхүүгийн чиглэлээр | 82,5% | А/Байр хариуцсан менежер албан хаагчдын эд хөрөнгийн дотоод хөдөлгөөнийг цаг тухай бүрд нь хийлгэх,<br>Б/Цэвэрлэгээний бараа материалын зарцуулалт нь тухайн сардаа хангалттай хүрэлцдэг_ |
| 4 | IV.ХАБЭА, Стандарт норм норматив, хэрэгжүүлж буй байдал | 78% | 2021 оны А/10 дугаар тушаалаар баталсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий шаардлага” 2019 оны А/18 дугаар тушаалаар баталсан “Ажлын байрны цэвэрлэгээ үйлчилгээ, үйлчилгээний ерөнхий шаардлага” /НҮГ-01:2019/ хэрэгжиж байгаа хэдий ч сурталчлан таниулах ажил хийгдэх шаарллагатай, ариутгал |

| | | | |
|---|---|---|---|
| | | | халдваргүйжүүлэлтийн бүртгэл хөтөлдөггүй, нэг бүрийн хамгаалах хэрэгслийг хэрэглэж хэвшсэн байна. |
| 5 | V.Төлөвлөгөө тайлан, батлагдсан хуваарийг хэрэгжүүлж ажиллах чиглэлээр | 78% | Гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний биелэлт тайлагнасан байдалтай танилцахад албан тушаалын тодорхойлолтын зорилтын хүрээнд хийгдэх арга хэмжээг бүрэн тусгаагүй, төлөвлөлт хэт ерөнхий, тодорхой бус,<br>Баримт бичиг боловсруулахдаа /Төлөвлөгөө, тайлан, илтгэх хуудас, мэдээлэл, судалгаа/ баримт бичгийн бүрдэл хангаагүй, |
| 6 | VI.Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах чиглэлээр | 91% | - |
| **Ерөнхий үнэлгээ** | | 78% | |

## 11.Баянхошуу дэд төв

Ажлын хэсэг 2023.11.24-ний өдрийн 11:00-12:00 цагийн хооронд тус байранд ажиллалаа. Менежер А.Нямсүрэн тус нэгдсэн төвийн 4, хувийн хэвшил 23 байгууллагын 78 гаруй албан хаагчдын ая тухыг хангахаар 14 ажилтан 08:00 цагаас 17:30 цаг хүртэл цэвэрлэгээ үйлчилгээг хариуцан ажиллаж байна. Цэвэрлэгээ үйлчилгээний талбай – 2173м2

Ажиллавал зохих: 9 ажилтан
Ажиллаж байгаа 9 ажилтан



Зураг 27. Баянхошуу дэд төвийн байр


Зураг 28. Байр хариуцсан менежерийн өрөө

Баянхошуу төвийн үнэлгээний нэгтгэл

| № | Шалгах чиглэл, шалгуур үзүүлэлт | Хэсгийн дундаж үнэлгээний хувь | Үнэлгээний үндэслэл, тайлбар |
|---|---|---|---|
| 1 | I.Хууль, тогтоомж дүрэм журмын чиглэлээр | 70% | Албан хэрэг, хөтлөлтийн стандартыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилладаггүй. Мөрдөгдөж байгаа дүрэм журмуудыг хэвлэж, хавтасласан боловч судлаагүй, ажилтан албан хаагчдад тайлбарлан таниулж гарын үсгээр баталгаажуулаагүй. |
| 2 | II.Хүний нөөцийн чиглэлээр | 69% | -Ажилчдын хувийн хэрэг үүсгэсэн нь Төрийн албаны тухай хууль 15.1 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоол “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам” Төрийн албан хаагч бүрд зөвхөн нэг хувийн хэрэг хөтөлнө. Хувийн хэргийг тухайн албан хаагчийн ажиллаж буй байгууллагын захиргаанд |

| | | | |
|---|---|---|---|
| | | | хадгална гэсэн заалтыг зөрчсөн.<br>-Хамт олны уур амьсгал, тэдгээрийг идэхжүүлэх зорилгоор дотооддоо шинээр ажил зохион байгуулаагүй,<br>-Бичиг баримтыг тухай бүр баталгаажуулан хавтас үүсгэдэггүй, бичиг баримтын стандарт хангалтгүй эмх цэгцгүй, он оны бичиг баримт холилдсон,<br>-Их цэвэрлэгээ ариутгалын хуваарийг газрын даргаар батлуулсан ч 100% дагаж мөрддөггүй<br>-Өдөр тутмын цэвэрлэгээ хийсэн тухай тэмдэглэл, цэвэрлэгээ үйлчилгээг шалгах хяналтын хуудсыг тухай бүрт бүрэн гүйцэд хянаагүй<br>-Захиргаанаас гарсан шийдвэр холбогдох мэдээ мэдээллийг ажилчдад тогтмол мэдээлсэн тухай хурлын тэмдэглэл хөтөлж баталгаажуулдаггүй зөрчлүүд илэрлсэн болно. |
| 3 | III.Төсөв, санхүүгийн чиглэлээр | 82,5% | А/Байр хариуцсан менежер албан хаагчдын эд хөрөнгийн дотоод хөдөлгөөнийг цаг тухай бүрд нь хийлгэх<br>Б/Цэвэрлэгээний бараа материалын зарцуулалт нь тухайн сардаа хангалттай хүрэлцдэг |
| 4 | IV.ХАБЭА, Стандарт норм норватив, хэрэгжүүлж буй байдал | 78% | 2021 оны А/10 дугаар тушаалаар баталсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий шаардлага” 2019 оны А/18 дугаар тушаалаар баталсан “Ажлын байрны цэвэрлэгээ үйлчилгээ, үйлчилгээний ерөнхий шаардлага” /НҮГ-01:2019/ хэрэгжиж байгаа хэдий ч сурталчлан таниулах ажил хийгдэх шаардлагатай, ариутгал халдваргүйжүүлэлтийн бүртгэл хөтөлдөггүй, нэг бүрийн хамгаалах хэрэгслийг хэрэглэж хэвшсэн байна. |
| 5 | V.Төлөвлөгөө тайлан, батлагдсан хуваарийг хэрэгжүүлж ажиллах чиглэлээр | 76% | Гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний биелэлт тайлагнасан байдалтай танилцахад албан тушаалын тодорхойлолтын зорилтын хүрээнд хийгдэх арга хэмжээг бүрэн тусгаагүй, төлөвлөлт хэт ерөнхий, тодорхой бус,<br>Баримт бичиг боловсруулахдаа /Төлөвлөгөө, тайлан, илтгэх хуудас, мэдээлэл, судалгаа/ баримт бичгийн бүрдэл хангаагүй, |
| 6 | VI.Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах чиглэлээр | 100% | - |
| **Ерөнхий үнэлгээ** | | 79% | |

## ДҮГНЭЛТ

Дотоод хяналт шалгалтын ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2023.11.17-11.24-ний өдрүүдэд тус газрын 11 байранд очиж ажиллалаа.

Шалгалтын ажлын хэсгийн албан хаагчид ажил үүргийн хүрээнд шалгах чиглэл, шалгуур үзүүлэлтийн дагуу Хяналт шалгалтын тэмдэглэл хөтөлж, ажил дүгнэсэн байдал, үнэлгээг илтгэх хуудсыг ажлын хэсгийн нарийн бичиг Б.Ууганцэцэгт ирүүлснийг нэгтгэлээ.

АЖИЛТАН, АЛБАН ХААГЧДААС ИРҮҮЛСЭН НИЙТЛЭГ САНАЛ ХҮСЭЛТ:

| д/д | Байр | Ажилчдаас гарсан санал, гомдол<br>Ажилчдаас гарсан гомдол |
|---|---|---|
| 1 | 2 | 3 |
| 1 | Төр захиргааны цогцолбор байр, 1,2,3,4,5, НҮНТ Драгон, Дүнжингарав, Мишээл, Дэд төв Сэлбэ, Баянхошуу, | Шинээр олгосон ажлын хувцас материал сунадаггүй материалтай хөдөлгөөн хязгаарлаж, өмд доор суудалтай учир шувтрах, оёдлоороо ханзрах асуудлууд байна. |

| | | |
|---|---|---|
| 2 | Төр захиргааны цогцолбор, НҮНТ Мишээл салбар, Баянхошуу дэд төв, НҮНТ Дүнжингарав салбар, 2,3,4,5 | Хүний нөөцийн дутагдлаас үүдэлтэй ажил хавсран гүйцэтгэх тохиолдол их гарч байгаа хавсрангийн нэмэгдэл цалинг бодож олгох, 3 сар гэж дотоод журамд заасныг удирдлагууд эргэн харах, |
| 3 | Сэлбэ дэд төв | Угтах үйлчилгээний ажилтан ажилд авах |
| 4 | Төр захиргааны цогцолбор байр | Хол гэртээ учир өглөөний цагийн 30 мин хойшлуулж, оройн цагт нэмж өгөхийг хүссэн |
| 5 | Угтах үйлчилгээний ажилчид | Ажилчдын хувцас олгохыг хүссэн |
| 6 | Баянхошуу дэд төв | Хувцас олгогч ажилд авах |

НЭН ШААРДЛАГАТАЙ АЖЛЫН БАГАЖ, ХЭРЭГСЭЛ

| д/д | Байр | Нэн шаардлагатай ажлын багаж,тоног төхөөрөмж |
|---|---|---|
| 1 | 2 | 3 |
| 1 | Төр захиргааны цогцолбор байр, 1,2,3,4,5, НҮНТ Драгон, Дүнжингарав, Мишээл, Дэд төв Сэлбэ, Баянхошуу, | - Тоос сорогч<br>- Хивс угаагч машин<br>- Шал арчигч 60-тай сэгсгэр<br>- 00н сойз<br>- Цас хусдаг дугуйтай тэрэг<br>- Плита өнгөлөгч |
| 2 | Ариун цэврийн үйлчлэгчид | Малгай маск, 00-н гар сойзыг урт иштэй сойзоор солих, жавиланаас өөр сүүлийн үеийн ариутгалын бодис |
| 3 | Төр захиргааны цогцолбор байр | 00-н крантнаас байнга зэвтэй ус шүүрдэг учир крантыг тойроод тавцан нь шарласан учир зэв арилгадаг бодис авмаар байна |
| 4 | НЗЗ-ны 2-р байр | Зарим давхаруудаас бохирын үнэр маш ихээр гардаг тул үнэр дарагч, ариутгалын бодис авах, |

**1.Хууль, тогтоомж дүрэм журмын чиглэлээр:**

Хууль, эрх зүйн асуудал хариуцсан ажилтан Ю.Хүслэн 10 шалгуур үзүүлэлтээр шалгаж, үнэлэлт дүгнэлт өгсөн.

- Байр хариуцсан менежерүүд байгууллагад мөрдөгдөж байгаа дүрэм журмуудыг хэвлэж, хавтасласан боловч судалж танилцаагүй, ажилтан албан хаагчдад тайлбарлан таниулж гарын үсгээр баталгаажуулаагүй.
- Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг мэдээллийн самбарт байршуулсан хэдий ч албан хаагчид дотоод журмын тухай мэдлэг, ойлголт байхгүй байна.
- Хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулалт хангалтгүй, тайлагнахдаа алба хэрэг хөтлөлтийн стандартыг мөрддөггүй, цаасан суурьтайгаар үйлдэж гарын үсэг зурж баталгаажуулдаггүй байна.
- Хүчин төгөлдөр бус захирамжлалын баримт бичгийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байгаа нь дутагдалтай.
- Төрийн албаны ёс зүйн тухай хууль 2023 онд шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан байгууллага болгон дээр ёс зүйн дэд хороо байгуулагдаж байгаа, ёс зүйн дүрэм шинэчлэгдэж байгаа, батлагдсаны дараа бүх албан хаагчдад танилцуулга хийнэ. Ажлаа хийж байхдаа олж авсан мэдээллийг задруулахгүй, хов болгож ярихгүй байх, Хөдөлмөрийн дотоод журам шинэчлэгдэхээр санал авсан нэгтгэгдэж байгаа талаар мэдээлэл өгсөн.

**2.Хүний нөөцийн чиглэлээр:**

Хүний нөөцийн Ахлах мэргэжилтэн Т.Азжаргал 6 шалгуур үзүүлэлтээр шалгаж дүгнэхэд:

- Байр хариуцсан менежерүүд нь байр болгон дээр ажилчдын хувийн хэрэг үүсгэсэн Төрийн албаны тухай хууль 15.1 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоол “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам” Төрийн албан хаагч бүрд зөвхөн нэг хувийн хэрэг хөтөлнө. Хувийн хэргийг тухайн албан хаагчийн ажиллаж буй байгууллагын захиргаанд хадгална гэсэн заалтыг зөрчсөн.
- Ажлаас чөлөөлөгдсөн ажилтантай ажил хүлээлцэх акт үйлдэж баталгаажуулаагүй,
- Хамт олны уур амьсгал, тэдгээрийг идэвхжүүлэх зорилгоор дотооддоо шинээр ажил зохион байгуулаагүй,
- Бичиг баримтыг тухай бүр баталгаажуулан хавтас үүсгэдэггүй, бичиг баримтын стандарт хангалтгүй эмх цэгцгүй, он оны бичиг баримт холилдсон,
- Их цэвэрлэгээ ариутгалын хуваарийг газрын даргаар батлуулаагүй, зарим байр батлуулсан ч мөрддөггүй,
- Өдөр тутмын цэвэрлэгээ хийсэн тухай тэмдэглэл, цэвэрлэгээ үйлчилгээг шалгах хяналтын хуудсыг тухай бүрд бүрэн гүйцэд хянаагүй, 10 сараас эхлэн тэмдэглэл хөтөлсөн,
- Захиргаанаас гарсан шийдвэр холбогдох мэдээ мэдээллийг ажилчдад тогтмол мэдээлсэн тухай хурлын тэмдэглэл хөтөлж баталгаажуулдаггүй зөрчлүүд илэрсэн болно.

**3.Төсөв санхүүгийн чиглэлээр:**

Тооцооны нягтлан бодогч Б.Бямбаа 2 шалгуур үзүүлэлтээр үнэлж дүгнэхэд:

- Хяналт шалгалтын үеэр 2023 оны жилийн эцсийн өмч хөрөнгийн тооллого байруудад хийгдсэн бөгөөд дараах нийтлэг дутагдал байна.
- А/Байр хариуцсан менежер тооллого хийх явцад эд хөрөнгө хариуцагчийн картан дээр байгаа хөрөнгөө мэдэхгүй байгаа нь дутагдалтай. Зоогийн газрын тоног төхөөрөмж, материалын ашиглалт хамгаалалт хангалтгүй.
- Б/Цэвэрлэгээний бараа материалын хүрэлцээ хангалттай байдаг, зарим нунтаг цэвэрлэгээний бодисуудыг үйлчилгээний ажилчид урт хугацаанд ашигласны улмаас харшил өгөх магадлалтай тул маск зүүлгэх шаардлагатай.

**4.ХАБЭА, стандарт норм норматив хэрэгжүүлж буй чиглэлээр:**

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтан Б.Жаргалсайхан 4 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд

- 2021 оны А/10 дугаар тушаалаар баталсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий шаардлага”

- 2019 оны А/18 дугаар тушаалаар баталсан “Ажлын байрны цэвэрлэгээ үйлчилгээ, үйлчилгээний ерөнхий шаардлага” /НҮГ-01:2019/ бүрэн хэрэгжилгүй байна. Сурталчлан таниулах ажил хийгдэх, өдөр тутмын болон давтан зааварчилгаа өгөх шаардлагатай, ариутгал халдваргүйжүүлэлтийн бүртгэл хөтөлдөггүй, нэг бүрийн хамгаалах хэрэгслийг хэрэглэж хэвшсэн байна.

**5.Төлөвлөгөө, тайлан, батлагдсан хуваарийг хэрэгжүүлж ажиллах чиглэлээр**: Захиргааны Ахлах мэргэжилтэн Т.Азжаргал, Дотоод хяналт- шинжилгээ үнэлгээ хариуцсан ажилтан Б.Ууганцэцэг нар 9 шалгуур үзүүлэлтээр үнэлсэн.

- Байр хариуцсан менежерүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний биелэлт тайлагнасан байдалтай танилцахад албан тушаалын тодорхойлолтын зорилтын хүрээнд хийгдэх арга хэмжээ, үйл явц бүрийг бүрэн тусгаагүй, төлөвлөлт хэт ерөнхий, тодорхой бус байгааг цаашид анхаарах шаардлагатай байна.
- Байр хариуцсан менежерүүд зохион байгуулалтын болон мэдээлэл лавлагааны баримт бичиг боловсруулахдаа /Төлөвлөгөө, тайлан, илтгэх хуудас, мэдээлэл, судалгаа/ баримт бичгийн бүрдэл хангаагүй, архив албан хэрэг хөтлөлтийн стандарт, шаардлага хангалтгүй байна. Жишээ нь: Цаасны хэмжээ, захын зайг тохируулаагүй, хуудас дугаарлаагүй, монгол хэлний найруулга зүй, зөв бичих дүрмийн алдаатай, боловсруулсан баримтын нэр, гарчиг, огноо, дугаар, баталсан зөвшөөрсөн тухай тэмдэглэл дутуу, холбогдох албан тушаалтнаар гарын үсэг зуруулж, тамга тэмдгээр баталгаажаагүй төлөвлөгөө олон нийтийн мэдээллийн самбарт байршуулсан, цаасаар хэвлэж баталгаажуулаагүй, архив албан хэрэг хөтлөлтийн стандартыг ханган ажилладаггүй зэрэг зөрчил илэрснийг тухай бүрт зөвлөгөө өгч ажилласан.

**6.Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах чиглэлээр 3 шалгуур үзүүлэлтээр:** Ерөнхий инженер Б.Батсүрэн үнэлсэн.

- Нийслэлийн Засаг Захиргааны байрууд болон НҮНТ, Сэлбэ, Баянхошуу дэд төвүүдийн өвөлжилтийн бэлтгэн ажил бүрэн хангагдаж халаалт, дулааны хангах хэрэгсэл бүрэн халааж НЗЗ-ны байрууд болон дэд төвүүд системийн доголдолгүй хэвийн ажиллаж байна.



Зураг 29. Инженерийн шугам сүлжээний график үзлэгийн хуудас

Хуваарьт инженерийн үзлэгээр:

- Сантехникийн чиглэлээр: НЗЗ-ны 3-р байрны ялтсан бойлероос усны алдагдалтай.
- Цахилгааны чиглэлээр: НЗЗ-ны 1, 2-р байр нийтийн эзэмшлийн коридор болон ариун цэврийн өрөөний гэрэлтүүлгийг ханган ажиллах. НЗЗ-ны 3-р

байранд B1 давхрын ил гарсан утсыг далдлах, цэгцлэх шаардлагатай байсан.

- Холбоо дохиолол, сүлжээний чиглэлээр: НЗЗ-ны 4-р байрны хойд шатны сүлжээний утас цэгцлэх, хяналтын өрөөний бичигчийг янзлах. НЗЗ-ны 1-р байрны нийтийн эзэмшлийн сүлжээ, холбооны утас янзлах,
- Лифтний чиглэлээр: НЗЗ-ны 4-р байрны хойд лифтний мотор халсан, шал солих шаардлагатай. НЗЗ-ны 2-р байрны нэгдүгээр лифт савлагаатай түвшин үе үе алдах, гуравдугаар лифт хаалганы гулсагч дуугарч байгааг анхаарах шаардлагатай байна.

7.Үйлдвэрлэл үйлчилгээний албаны ерөнхий менежер Б.Ууганжаргал Байр хариуцсан менежерийн ёс зүй, харилцаа хандлагыг үнэлэх санал асуулгыг үйлчилгээний ажилчдаас 12 асуулгын дагуу авч судалгааг нэгтгэсэн.

- Хяналт шалгалтын явцад үйлчилгээний ажилчдаас ирсэн өргөдөл гомдлыг хүлээн авч ажиллалаа.

- Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дэвтрийг яаралтай шинэчлэн баталж байруудад тараах, цаашлаад мэргэжлийн онцлогоос үүдэлтэй хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны заавар зөвлөмж, сургалтыг нийт байрны ажилтнуудад зохион байгуулах,

- Зарим хэрэглэж байгаа цахилгаан хэрэгсэл ашиглалтын шаардлага хангахгүй, эвдрээд олон жилийн нүүр үзэж байгаа огтоос актлагдаагүй байрны менежерүүд байранд дээрээ цахилгаан хэрэгсэл тоног төхөөрөмжийн хөтлөлт байхгүй.

- НЗЗ-ны байруудад менежерүүд “Зөрчил тэмдэглэх дэвтэр” хөтөлдөггүй байсан тул шинээр зөрчил тэмдэглэх дэвтэр нээн ашиглуулж байна.

- Шинээр үйлчилгээний ажилд орсон ажилтнуудад анхан шатны сургалт явуулсан дэвтрийг байрны менежерүүд хөтлөх шаардлагатай байна.

- Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын бүртгэл, хэрэгжилтийг хангасан тухай бүртгэл тэмдэглэл хөтлөх шаардлагатай байна.

## БАЙР ХАРИУЦСАН МЕНЕЖЕРИЙН ЁС ЗҮЙ, ХАРИЛЦАА ХАНДЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЛААР ХИЙСЭН СУДАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ

/Үйлчилгээний ажилчдаас байр хариуцсан менежерийг үнэлэх судалгааны дүн сайн бол 6, Дунд бол 3, муу бол 1/

Уг санал асуулга нийт 118 үйлчилгээний албан хаагч хамрагдсан байна.

| д/д | Байр хариуцсан менежерийн нэр | Хариуцсан байр | Үйлчилгээний ажилчдаас байр хариуцсан менежерийг үнэлэх судалгааны тайлбар | Хамрагдсан ажилтны тоо Судалгааны нэгдсэн дүн /сайн бол 6, Дунд бол 3, муу бол 1/ |
|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Б.Оюунтуяа | Төр захиргааны цогцолбор байр | -Ёс зүй, харилцаа хандлага муу,<br>- Ажилчидтай элдэг таатай, ижил тэгш харилцдаг байдал,<br>-Ажилдаа хариуцлагатай ханддаг байдал,<br>-Ажлыг зөв тэнцвэртэй хуваарилан, зохион байгуулах ур чадвар, мэргэжил арга зүйн зөвөлгөө өгдөг байдал,<br>-Багаар ажиллах,<br>Асуудлыг түргэн шуурхай бүрэн шийдвэрлэдэг байдал, | Санал асуулгад хамрагдсан ажилтны тоо-10<br><br>Дундаж үнэлгээ 1 буюу /Маш хангалтгүй/ |
| 2 | Б.Наранцэцэг | Төр захиргааны цогцолбор байр | - Ажилчидтай элдэг таатай, ижил тэгш харилцдаг байдал,<br>-Ажлыг зөв тэнцвэртэй хуваарилан, зохион байгуулах ур чадвар, мэргэжил арга зүйн зөвөлгөө өгдөг байдал,<br>Ажилдаа хариуцлагатай ханддаг байдал, | Санал асуулгад хамрагдсан ажилтны тоо-9<br><br>Дундаж үнэлгэз 3 буюу /дунд/ |
| 3 | Ж.Отгонцэцэг | НЗЗ-ны 1-р байр | -Ёс зүй, харилцаа хандлага муу,<br>- Ажилчидтай элдэг таатай, ижил тэгш харилцдаг байдал,<br>-Ажлыг зөв тэнцвэртэй хуваарилан, зохион байгуулах ур чадвар, мэргэжил арга зүйн зөвөлгөө өгдөг байдал, | Санал асуулгад хамрагдсан ажилтны тоо-10<br><br>Дундаж үнэлгээ 3 буюу /дунд |
| 4 | Б.Анхтуяа | НЗЗ-ны 2-р байр | -Ёс зүй, харилцаа хандлага муу,<br>- Ажилчидтай элдэг таатай, ижил тэгш харилцдаг байдал,<br>-Ажлыг зөв тэнцвэртэй хуваарилан, зохион байгуулах ур чадвар, мэргэжил арга зүйн зөвөлгөө өгдөг байдал,<br>Ажилдаа хариуцлагатай ханддаг байдал, | Санал асуулгад хамрагдсан ажилтны тоо-18<br><br>Дундаж үнэлгээ 3 буюу /дунд/ |
| 5 | С.Мөнхцэцэг | НЗЗ-ны 3-р байр | -Ёс зүй, харилцаа хандлага муу,<br>- Ажилчидтай элдэг таатай, ижил тэгш харилцдаг байдал,<br>-Ажлыг зөв тэнцвэртэй хуваарилан, зохион байгуулах ур чадвар, мэргэжил арга зүйн зөвөлгөө өгдөг байдал, | Санал асуулгад хамрагдсан ажилтны тоо-10<br><br>Дундаж үнэлгээ 3 буюу /дунд/ |
| 6 | Б.Мөнхцэцэг | НЗЗ-ны 4-р байр | -Ёс зүй, харилцаа хандлага муу,<br>-Ажилчидтай элдэг таатай, ижил тэгш харилцдаг байдал, | Санал асуулгад хамрагдсан ажилтны тоо-14 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | -Ажлыг зөв тэнцвэртэй хуваарилан, зохион байгуулах ур чадвар, мэргэжил арга зүйн зөвөлгөө өгдөг байдал, | Дундаж үнэлгээ 3 буюу /дунд |
| 7 | М.Догсом | НЗЗ-ны 5б,в-р байр | - | Санал асуулгад хамрагдсан ажилтны тоо-12<br><br>Дундаж үнэлгээ 6 буюу /Сайн/ |
| 8 | А.Хулан | НЗЗ-ны 5а-р байр | -Ажилчидтай эелдэг таатай, ижил тэгш харилцдаг байдал,<br>-Ажлыг зөв тэнцвэртэй хуваарилан, зохион байгуулах ур чадвар, мэргэжил арга зүйн зөвөлгөө өгдөг байдал,<br>-Цаг ашиглах баримтлах байдал,<br>-Ажилдаа хариуцлагатай ханддаг байдал, | Санал асуулгад хамрагдсан ажилтны тоо-6<br><br>Дундаж үнэлгээ 1 буюу /маш хангалтгүй/ |
| 9 | Д.Мөнхсайхан | НҮНТ Драгон | - | Санал асуулгад хамрагдсан ажилтны тоо-6<br><br>Дундаж үнэлгээ 6 /Сайн/ |
| 10 | Б.Туяасайхан | НҮНТ Дүнжингарав салбар | -Ёс зүй, харилцаа хандлага муу,<br>- Ажилчидтай эелдэг таатай, ижил тэгш харилцдаг байдал,<br>-Ажлыг зөв тэнцвэртэй хуваарилан, зохион байгуулах ур чадвар, мэргэжил арга зүйн зөвөлгөө өгдөг байдал, | Санал асуулгад хамрагдсан ажилтны тоо-9<br><br>Дундаж үнэлгээ 3 буюу /дунд |
| 11 | Ц.Өнөрбилэг | Сэлбэ дэд төв | - Ажилчидтай эелдэг таатай, ижил тэгш харилцдаг байдал,<br>-Ажлыг зөв тэнцвэртэй хуваарилан, зохион байгуулах ур чадвар, мэргэжил аргазүйн зөвөлгөө өгдөг байдал,<br>-Цаг ашиглах баримтлах байдал | Санал асуулгад хамрагдсан ажилтны тоо-7<br><br>Дундаж үнэлгээ 3 буюу /дунд |
| 12 | А.Нямсүрэн | Баянхошуу дэд төв | - Ажилчидтай эелдэг таатай, ижил тэгш харилцдаг байдал,<br>-Ажлыг зөв тэнцвэртэй хуваарилан, зохион байгуулах ур чадвар, мэргэжил арга зүйн зөвөлгөө өгдөг байдал,<br>-Цаг ашиглах баримтлах байдал | Санал асуулгад хамрагдсан ажилтны тоо-6<br><br>Дундаж үнэлгээ 3 буюу /дунд |
| 13 | Б.Номин-Эрдэнэ | НҮНТ Мишээл салбар | - | Санал асуулгад хамрагдсан ажилтны тоо-2<br>Дундаж үнэлгээ 6 /Сайн/ |

Ажлын хэсгийн ерөнхий үнэлгээний нэгтгэл

| № | Байр, байр хариуцсан менежерийн нэр | Ерөнхий үнэлгээ | Судалгааны нэгдсэн дүн |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1 | НҮНТ Драгон, Д.Мөнхсайхан | 80% | 6 буюу сайн |
| 2 | 4 дүгээр байр, Б.Мөнхцэцэг | 79% | 3 буюу дунд |
| 3 | Баянхошуу дэд төв, А.Нямсүрэн | 79% | 3 буюу дунд |
| 4 | 5 дугаар байр, М.Догсом | 78% | 6 буюу сайн |
| 5 | 3 дугаар байр, С.Мөнхцэцэг | 78% | 3 буюу дунд |
| 6 | Сэлбэ дэд төв, Ц.Өнөрбилэг | 78% | 3 буюу дунд |
| 7 | 1 дүгээр байр, Ж.Отгонцэцэг | 77% | 3 буюу дунд |
| 8 | НҮНТ Дүнжингарав салбар, Б.Туяасайхан | 76% | 3 буюу дунд |
| 9 | 2 дугаар байр, Б.Анхтуяа | 76% | 3 буюу дунд |
| 10 | Төр захиргааны цогцолбор байр Б.Наранцэцэг | 76% | 3 буюу дунд |
| 11 | Төр захиргааны цогцолбор байр Б.Оюунтуяа | 76% | 1 буюу маш хангалтгүй |
| 12 | НҮНТ Мишээл салбар, Б.Номин-Эрдэнэ | 74% | 6 буюу сайн |
| 13 | 5 дугаар байр, А.Хулан | - | 1 буюу маш хангалтгүй |

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН
АЖЛЫН ХЭСГИЙН НАРИЙН БИЧИГ Б.УУГАНЦЭЦЭГ

НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР

ЗӨВЛӨМЖ

2023 оны 11 дүгээр сарын 27 Улаанбаатар хот

Нийслэлийн Засаг захиргааны байруудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн тухай

Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын даргын баталсан хяналт шалгалт хийх тухай №06 дугаар удирдамжийн дагуу Нийслэлийн засаг захиргааны байруудын /11/ үйл ажиллагаанд 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрөөс 11 дүгээр сарын 24-ний өдөр хүртэлх хугацаанд хяналт шалгалт хийж ажилласан.

Хяналт шалгалт хийхдээ Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр т огтоолоор баталсан “Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам” Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/727 дугаар захирамжаар баталсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам” болон байгууллагын дотоод хяналтын журам бусад холбогдох хууль тогтоомжийг үндэслэл болгосон.

Хяналт шалгалтын удирдамжийг Нийслэлийн Засаг захиргааны байрны менежерүүд, ажилчдад танилцуулж, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал, цаашид анхаарах асуудлын талаар тухай бүр ажилтнуудад танилцуулсан.

Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах чиглэлээр дараах санал, зөвлөмжийг хүргүүлж байна.

- Ажилчдын хувийн хэргийг “Төрийн албаны тухай хууль 15.1 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоол “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам” Төрийн албан хаагч бүрд зөвхөн нэг хувийн хэрэг хөтөлж, Хувийн хэргийг тухайн албан хаагчийн ажиллаж буй байгууллагын захиргаанд хадгална” гэсэн заалтыг мөрдөж, байр байрандаа ажилчдын хувийн хэргийг давхардуулж нээхгүй байх,
- Тухайн байранд ажилтанд бүртгэлтэй эд хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг ажилтан солигдох тухай бүрд хийж эд хөрөнгө хариуцагчийн картад тэмдэглэх,
- Байгууллага дотооддоо мөрдөгдөж байгаа дүрэм журмуудыг ажилчдад давтан тайлбарлан таниулж гарын үсгээр баталгаажуулах,

- Хамт олны уур амьсгалыг сайжруулах, идэвхжүүлэх зорилгоор дотооддоо шинээр ажил санаачлан зохион байгуулах,
- Байр хариуцсан менежерүүд зохион байгуулалтын болон мэдээлэл лавлагааны баримт бичиг боловсруулахдаа /Төлөвлөгөө, тайлан, илтгэх хуудас, мэдээлэл, судалгаа г.м/ баримт бичгийн бүрдэл хангаагүй, архив албан хэрэг хөтлөлтийн стандарт, шаардлага хангалтгүй байна. Жишээ нь: Цаасны хэмжээ, захын зайг тохируулаагүй, хуудас дугаарлаагүй, монгол хэлний найруулга зүй, зөв бичих дүрмийн алдаатай, боловсруулсан баримтын нэр, гарчиг, огноо, дугаар, баталсан зөвшөөрсөн тухай тэмдэглэл дутуу, холбогдох албан тушаалтнаар гарын үсэг зуруулж, тамга тэмдгээр баталгаажаагүй төлөвлөгөө олон нийтийн мэдээллийн самбарт байршуулсан" зэрэг зөрчил илэрсэн тул цаашид анхаарч ажиллах,
- Байр хариуцсан менежерүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний биелэлт тайлагнасан байдалтай танилцахад албан тушаалын тодорхойлолтын зорилтын хүрээнд хийгдэх арга хэмжээг бүрэн тусгаагүй, төлөвлөлт хэт ерөнхий, тодорхой бус байгааг цаашид анхаарах,
- "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий шаардлага" "Ажлын байрны цэвэрлэгээ үйлчилгээ, үйлчилгээний ерөнхий шаардлага" /НҮГ-01:2019/ хэрэгжүүлэх, сурталчлан таниулах, өдөр тутмын болон давтан зааварчилгаа өгөх шаардлагатай, ариутгал халдваргүйжүүлэлтийн бүртгэл хөтөллөх, нэг бүрийн хамгаалах хэрэгслийг хэрэглэх,
- Судалгаагаар Байрны менежерийн ёс зүй, харилцаа хандлага хангалтгүй дүгнэгдсэн тул, байр хариуцсан менежер, үйлчилгээний ажилчид ёс зүй харилцаа хандлагаа сайжруулах,
- Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын бүртгэл, хэрэгжилтийг ханган, эргэх холбоотой ажиллах, байранд гарсан аливаа зөрчлийг тэмдэглэх дэвтэр хөтлөх, мэдээлэлтэй байх,
- Шинээр үйлчилгээний ажилд орсон ажилтнуудад анхан шатны сургалт явуулсан дэвтрийг хөтөлж ажиллахыг зөвлөе.

БОЛОВСРУУЛСАН:
ДОТООД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ
АЖИЛТАН Б.УУГАНЦЭЦЭГ